



МӨНГӨНИЙ БОДЛОГЫН МЭДЭГДЭЛ

Дугаар: 2010/10
Огноо: 2010 оны 10-р сарын 21
Эмбарго: 2010 оны 10-р сарын 22-ны Баасан гаригийн 11:00 цаг хүртэл

Монголбанкны Захирлуудын зөвлөл 10 дугаар сарын 21-нд хуралдаж бодлогын хүүг өөрчлөхгүй байх шийдвэр гаргалаа.

Үндэсний Статистикийн хорооны мэдээгээр 2010 оны 9 дүгээр сарын байдлаар инфляци улсын хэмжээнд жилийн 10.6 хувь, Улаанбаатар хотод 10.9 хувь байна. Оны эхний хагаст эрчимтэй нэмэгдэж байсан инфляцийн өсөлт 3 дугаар улиралд буурлаа.

Макро эдийн засгийн бодлогыг тодорхойлох 2011 оны төсвийн төсөл УИХ-аар хэлэлцэж эхлээгүй байна. Мөн түүнчлэн Засгийн газар УИХ-д өргөн бариад буй төсвийн төслөөс гадуур ихээхэн хэмжээний хөрөнгийг гаднаас татаж хөрөнгө оруулалтын том том төслүүд хэрэгжүүлэх зорилготой байгаа тухайгаа мэдэгдэж байгаа ч эдгээрийн хэмжээ, цаг хугацааны хуваарь тодорхойгүй байна. Эдгээр тодорхой бус байдал мөнгөний бодлогын хүүг бууруулах боломжийг хязгаарлаж байна.

МОНГОЛБАНК